

ГИХГ-ЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН 2018 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРД
ХИЙХ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2018.03.26-2018.04.25/

2018 оны 03 дугаар сарын 26

Даланзадгад сум

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх ажил	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5
Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр				
1	Монгол Улсад байх хөрөнгийн баталгаагүй, визийн ангиллаас өөр зорилгоор ирж буй гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг тодорхой бүрдүүлэн, бүртгэл хөтлөж ажиллах.	1. Холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах. 2. Бүртгэл хөтлөх.	Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцааж буй үндэслэл тодорхой байна.	Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар
2	Виз, урилга олголт, визийн шилжүүлэг, түр болон удаан хугацаагаар ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шуурхай хуулийн дагуу шийдвэрлэн, бүртгэл хөтлөж мэдээллийн санд баяжилт хийх.	1. Виз олгох. 2. Визийн шилжүүлэг хийх. 3. Бүртгэл, хасалт хийх.	Хуулийн дагуу хийгдсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар
3	Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийн баримт бичигт хийх хяналт шалгалтыг дангаар буюу бусад байгууллагатай хамтран зохион байгуулах.	1. Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Хуулийн дагуу хийгдсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар
4	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газар, гэр бүлийн болон цагаач, хувийн бусад зорилгоор оршин сууж буй гадаадын	1. Гадаадын иргэдийн мэдээллийг ISM программ дээр шалгах.	Гадаадын иргэдэд тавих хяналт сайжирсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар

	иргэд, харьяалалгүй хүний бүртгэл хөтлөж, мэдээллийн санд баяжилт хийх.			
5	Зөрчил гаргасан гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын асуудлыг зохих хууль, журмын дагуу шуурхай шийдвэрлэх.	1. Илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх.	Хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар
6	ГИЭЗБТХ зөрчсөн гадаадын иргэдийг Монгол Улсаас албадан гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх.	1. Холбогдох хуулийн дагуу албадан гаргах ажлыг зохион байгуулж, Хяналт шалгалтын газарт танилцуулах.	Хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар
7	Өмнөд бүс дэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Гурван тэс, Ноён сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллагад ажиллаж буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах	1. Удирдамж батлуулах. 2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Хяналт шалгалтыг зохион байгуулж, гадаадын иргэдэд тавих хяналт сайжирсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар
8	ISM мэдээллийн санд тулгалт хийх, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчиж байгаа гадаад иргэдэд хяналт тавих	1. Гадаадын иргэдийн мэдээллийг ISM программ дээр шалгах.	Гадаадын иргэдэд тавих хяналт сайжирсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн
Хоёр. Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр				
9	Газрын даргын тушаал, газраас ирүүлсэн журам, шийдвэрийг тухай бүр албан хаагч нарт танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.	1. Байгууллагын даргын тушаал шийдвэрийг албан хаагч нарт танилцуулан, биелэлтэд хяналт тавих.	Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн
10	Албан хаагчдын сарын цагийн тооцоо гаргах, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийн саналыг дээд газарт хүргүүлэх.	1. Боомтод ажиллаж буй албан хаагчдын цагийн тооцоог хүлээн авч нэгтгэн санхүүд хүлээлгэн өгөх. 2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийн саналыг	Албан хаагчдын цалин хөлс хугацаандаа олгогдсон байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн

		хүлээлгэн өгөх.		
11	Албан хаагчдад холбогдох сургалт зохион байгуулах	1. Дотооддоо сургалт зохион байгуулах.	Сургалт зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг чадвар дээшилсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн
12	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын бэлтгэл ажлыг хангах	1. Өмнөговь аймгийн БОЭТ-тэй хамтран үзлэгийн нэр төрөл, санхүүгийн тооцоог судалж гаргах.	Эрүүл мэндийн үзлэгийн нэр төрөл, санхүүгийн тооцоог гаргасан байна. Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах бэлтгэл ажил хангагдсан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн, Ахлах нягтлан бодогч
Гурав. Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр				
13	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах. Албан хаагчдын цалин хөлс, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал засвар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж тусламж зэргийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.	1. Батлагдсан төсвийн дагуу зарцуулах. 2. Харилцагч байгууллагын нэхэмжлэлийн дагуу гүйлгээ хийх.	Төсвийг үр дүнтэй зарцуулсан байх.	Ахлах нягтлан бодогч
14	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог үнэн зөв гаргаж, холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнах.	1. Хяналтын улсын байцаагч нараас үнэт цаасны тайланг авч тулгалт хийн тайланг нэгтгэн гаргах.	Тайлан тооцоо хугацаандаа хүргэгдсэн байх.	Ахлах нягтлан бодогч Нярав
15	Авто машины ашиглалт, хяналт, техникийн бүрэн бүтэн байдал, жолоочийн хариуцлага, ур чадварт хяналт тавьж ажиллах.	1. Автомашины бүртгэл хяналтын дэвтрийг хөтлөн, жолоочийн хариуцлага, ур чадварт хяналт тавих.	Аюулгүй байдал хангагдсан байна.	Нярав
16	БНХАУ-ын Хилээр орох-гарах тэнхмийн буцалтгүй тусламжаар баригдах барилгын дотоод тохижилт, тавилга,	1. Шаардлагатай тавилга, техник хэрэгслийн судалгааг гаргах.	Тавилга, техник хэрэгслийн судалгааг хийж гаргасан байна.	Нярав Сүлжээний инженер

	техник хэрэгслийн судалгаа гаргах			
17	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ИТХ-ын “Торгуулийн орлогоос хийгдэх хөрөнгө оруулалтын тухай” тогтоол гаргуулах	1. Даланзадгад сумын ИТХ-ын ээлжит хуралд санал уламжлах.	ИТХ-ын тогтоол гарсан байна.	Газрын дарга, Хяналтын улсын ахлах байгцаагч
Дөрөв. Ирсэн өргөдөл, гомдол, архив, бичиг хэргийн чиглэлээр				
18	Баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах	1. Газраас болон бусад байгууллагаас ирсэн бичгийг холбогдох албан хаагчдад танилцуулах.	Хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн
19	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх.	1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэн картжуулах. 2. Холбогдох албан хаагчид шилжүүлж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх	Өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байх.	Захиргааны ахлах мэргэжилтэн
20	Тус газарт ирсэн, явсан албан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах	1. Ирсэн, явсан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл, гомдлыг скайнердах	Газарт ирсэн, явсан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл гомдлыг скайнердан цахим хэлбэрт оруулж, архив үүсгэсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн
Тав. Сүлжээ, програм хангамжийн чиглэлээр				
21	Сүлжээний тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.	1. Эвдрэл гэмтэл гарсан үед шуурхай засварлах	Сүлжээний тасралтгүй хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Сүлжээний инженер